



Дундговь аймаг дахь
Төрийн аудитын газар

Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн бодлого,
түүний хэрэгжилт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан
/УАГ-ГАГ/2017/10-ГА/



ААНОАТ-ын хөнгөлөлт,
чөлөөлөлтийг хууль
журмын дагуу эдэлсэн
боловч НӨАТ-аас
чөлөөлөгдөх орлогод
хамаарахгүй орлогод
чөлөөлөлт эдэлсэн
байна

<u>Тайланг бэлтгэсэн:</u>	Товчилсон үгс	3
Дундговь аймаг дахь Төрийн Аудитын газар	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	4-5
Дарга, тэргүүлэх аудитор Т.Оюунчимэг	Бүлэг 1. Орон нутгийн нийгэм, эдийн засагт татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн үзүүлэх нөлөө бага байна.	6-7
Аудитын менежер Х.Наранцацрал	<ul style="list-style-type: none"> Хөнгөлөлт, чөлөөлөлт эдэлсэн нийт орлогын 48 хувийг Засгийн газрын бондын хүүгийн орлого эзэлж байна. 	6
Ахлах аудитор Ч.Бэрхсайхан	<ul style="list-style-type: none"> Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн хэмжээ нийт төсвийн орлогын бага хувийг эзэлж байна. 	6-7
Аудитор Д.Должинсүрэн	Бүлэг 2. НӨАТ-аас чөлөөлөгдөхөөр тайлагнасан нийт орлогын 31 хувийг буруу тайлагнасан байна.	7-8
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70593208 дугаарын утас, 70592439 дугаарын факсаар харилцана уу.	<ul style="list-style-type: none"> НӨАТ-аас чөлөөлөгдөх орлогод хамаарахгүй орлогод чөлөөлөлт эдэлсэн байна. Хөдөлмөрийн чадвараа алдсан хөдөлмөр эрхэлдэг иргэд ХХОАТ-ын чөлөөлөлтөд бүрэн хамрагдахгүй байна. Татварын хэлтсийн хяналт шалгалтаар татварын хөнгөлөлт чөлөөлөлттэй холбоотой зөрчил илрээгүй байна. 	7-8 8 8
Уг тайланг ҮАГ-ын вэб сайтаас үзнэ үү. www.audit.mn	Дүгнэлт Дээд шатны байгууллагад хүргэх санал Зөвлөмж Шалгагдагч байгууллагаас ирүүлсэн Санал тайлбар Тайлан баталгаажуулсан тушаал Тайлангийн хавсралтууд	9 10 11 11-13
ХАЯГ: Сайнцагаан сум 7-р баг, Нутгийн удирдлагын ордон, 214 тоот		
2017 оны 9 дүгээр сар		

ТОВЧИЛСОН ҮГС

УИХ	Улсын Их Хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
ААНОАТ	Ах ахуй нэгжийн орлогын албан татвар
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт,

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх: Аудитыг УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2017 оны 2 дугаар тогтоол, Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон орон нутгийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Аудитын зорилт: Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн бодлого, түүний хэрэгжилт, үр дүнг шалгаж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдсэн.

Аудитын зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн талаарх бодлого, зохицуулалт үр дүнтэй хэрэгжиж байгаа эсэх
- Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд тавих хяналтын тогтолцоо үр нөлөөтэй эсэх.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлт: Дараах хууль эрх зүйн актын холбогдох заалтуудыг аудитын шалгуур үзүүлэлт болгон ашиглав.

- Татварын ерөнхий хууль;
- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль;
- Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль;
- Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулиуд;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль;
- Төсвийн тухай хууль;
- Төрийн аудитын тухай хууль;
- Дээрх хуулиудтай нийцүүлэн гаргасан дүрэм, журам, бусад эрхийн акт.

Аудитын хамрах хүрээ: Аудитыг 2015-2016 оны байдлаарх татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн талаар баримталсан бодлого, хөнгөлөлт, чөлөөлөлт эдэлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, төсөл хөтөлбөрийн судалгаа, бүртгэл тайлагнал, статистик мэдээ, дүн шинжилгээний бусад баримт материалд үндэслэн аймгийн Татварын хэлтэс, аж ахуйн нэгж, байгууллага, иргэнийг түүврийн аргаар хамруулан шалгалаа.

Аудитад НӨАТ, ААНОАТ-ын хөнгөлөлт, чөлөөлөлт, ХХОАТ-аас хөдөлмөрийн чадвараа 50 -иас дээш хувиар алдсан иргэдийн татварын хөнгөлөлтийг хамруулав.

Аудитын арга зүй: Аудитыг гүйцэтгэхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, Гүйцэтгэлийн аудитын журам болон гүйцэтгэлийн аудитын удирдамж /АДБОУС 3000-3100/-ийг ашиглан татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн талаар холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа, тодруулга авах, судалгаа, тайлан зэрэг баримт материалд тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ хийж, асуудлын шинжилгээ, арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж, дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Аудит хийх багийн бүрэлдэхүүн, хугацаа: Аудитын гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг дарга, тэргүүлэх аудитор Т.Оюунчимэг хянан удирдаж, аудитын менежер Х.Наранцацрал үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлэн, гүйцэтгэлийн аудитын багийн ахлах аудитор Ч.Бэрхсайхан 2017 оны 06 дугаар сарын 26-ны өдрөөс 2017 оны 09 дүгээр сарын 18-ний өдрийг дуустал хугацаанд гүйцэтгэлээ.

Ерөнхий мэдээлэл:

Аймгийн хэмжээнд 2015, 2016 онуудад татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэхээр тайлагнасан орлогын мэдээллийг дараах хүснэгтээр харууллаа.

Хүснэгт 1 мянган төгрөг

Татварын төрөл	Хөнгөлөлт эдлэхээр тайлагнасан орлого		Чөлөөлөлт эдлэхээр тайлагнасан орлого	
	2015	2016	2015	2016
НӨАТ			55,723.2	38,747.3
ААНОАТ	105.3	77.5	70,014.5	14,880.0

НӨАТ-ын чөлөөлөлт эдлэхээр 2015 онд 55,723.2 мянган төгрөг, 2016 онд 38,747.3 мянган төгрөгийн орлогыг тус тус тайлагнасан. ААНОАТ-ын чөлөөлөлт эдлэхээр

2015 онд 70,014.5 мянган төгрөг, 2016 онд 14,880.0 мянган төгрөгийн орлогыг, хөнгөлөлт эдлэхээр 2015 онд 105.3 мянган төгрөгийн орлогыг 2016 онд 77.5 мянган төгрөгийн орлогыг тус тус тайлагнасан байна.

Хөдөлмөрийн чадвараа 50-иас дээш хувиар алдсан иргэд ХХОАТ-аас чөлөөлөгдөх хүсэлтээ аймгийн Татварын хэлтэст гаргасны үндсэн дээр 2015 онд 5 иргэнийг, 2016 онд 23 иргэнийг татвараас чөлөөлөх тушаал гарсан байна.

Аймгийн хэмжээнд гаалийн албан татвар, онцгой албан татвар ногдох орлого байхгүй.


Бүлэг 1. Орон нутгийн нийгэм, эдийн засагт татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн үзүүлэх нөлөө бага байна.

Хөнгөлөлт, чөлөөлөлт эдэлсэн нийт орлогын 48 хувийг Засгийн газрын бондын хүүгийн орлого эзэлж байна.

1.1 2015 онд 3 аж ахуйн нэгж, байгууллагын нийт 70,014.5 мянган төгрөг, 2016 онд 2 аж ахуйн нэгж, байгууллагын 77.5 мянган төгрөгийн орлогод хууль, журмын дагуу ААНОАТ-ын хөнгөлөлт, чөлөөлөлт эдэлсэн байна.

1.2 НӨАТ-ын хувьд 2015 онд 2 аж ахуйн нэгж, байгууллагын 30,489.8 мянган төгрөг, 2016 онд 4 аж ахуйн нэгж, байгууллагын 34,303.5 мянган төгрөгийн орлогод хууль журмын дагуу чөлөөлөлт эдэлсэн байна.

График 1



1.3 Хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлсэн орлогыг салбараар ангилан харуулбал 71,594.5 мянган төгрөг буюу 48 хувийг санхүүгийн үйл ажиллагааны орлого эзэлж байна.

Тус орлогын 70,014.5 мянган төгрөг буюу 97.8 хувийг Тайшэндевелопмент ХХК-ийн Засгийн газрын бондын хүүгийн орлого эзэлж байна.

1.4 Эндээс харахад татварын хөнгөлөлт, чөлөөлөлт

үйлдвэрлэл, хөдөө аж ахуйн салбарт харьцангуй бага нөлөө үзүүлжээ.

Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн хэмжээ нийт төсвийн орлогын бага хувийг эзэлж байна.

1.5 НӨАТ-аас чөлөөлөгдсөн орлогын НӨАТ-ын орлогын дүнд эзлэх хувь 2015 онд 0.01, 2016 онд 0.01, нийт татварын орлогод 2015 онд эзлэх хувь 0.0004, 2016 онд 0.46 байна.

1.6 ААНОАТ-аас чөлөөлөгдсөн татварын орлого нь тухайн татварын орлогын дүнд эзлэх хувь 2015 онд 0.02, 2016 онд 0.003, нийт татварын орлогод эзлэх хувь 2015 онд 0.001, 2016 онд 0.2 байна.

1.7 НӨАТ, ААНОАТ-аас чөлөөлөгдөх орлогын дүн нь тухайн төрлийн татварын орлого болон нийт татварын орлогод бага хувь, хэмжээ эзэлж байгаа нь татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн хэрэгжилт нь орон нутгийн нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөө бага байгааг харуулж байна.

Бүлэг 2. НӨАТ-аас чөлөөлөгдөхөөр тайлагнасан нийт орлогын 31 хувийг бүрүү тайлагнасан байна.

НӨАТ-аас чөлөөлөгдөх орлогод хамаарахгүй орлогод чөлөөлөлт эдэлсэн байна.

2.1 НӨАТ-ын чөлөөлөлт эдлэхээр 2015 онд 7 аж ахуйн нэгж, байгууллага 55,723.2 мянган төгрөгийн орлого тайлагнаснаас 25,233.4 мянган төгрөгийн орлого буюу 47.0 хувийг буруу тайлагнаж, чөлөөлөлт эдэлсэн, 2016 онд 6 аж ахуйн нэгж, байгууллага 38,747.3 мянган төгрөгийн орлого тайлагнаснаас 4,443.7 мянган төгрөгийн орлого буюу 11.5 хувийг буруу тайлагнаж, чөлөөлөлт эдэлжээ. /Хавсралт 1/

Хүснэгт 2 /Мянган төгрөг/

Татвар төлөгчийн нэр	Чөлөөлөгдөх орлогын дүн		Хөнгөлөгдөх орлогын дүн	
	2015	2016	2015	2016
Тайшэндевелопмент ХХК	70,014.5			
Угтаал-Өгөөж ХХК			75.0	
ЭДОЧ ХХК			30.3	
ЭДОЧ ХХК				17.5
Угтаал-Өгөөж ХХК				60.0
Шувуутай-Оргил		14,880.0		
Нийт	70,014.5	14,880.0	105.3	77.5

2.2 ААНОАТ-ын хувьд чөлөөлөлт эдлэхээр 2015 онд 1 аж ахуйн нэгж, байгууллага 70,014.5 мянган төгрөгийн орлогыг, хөнгөлөлт эдлэхээр 2 аж ахуйн нэгж, байгууллага 105.3 мянган төгрөгийн орлого тайлагнаж хөнгөлөлт, чөлөөлөлт

эдэлсэн. 2016 онд 1 аж ахуйн нэгж, байгууллага чөлөөлөлт эдлэхээр 14,880.0 мянган төгрөгийн орлого тайлагнасныг чөлөөлөгдөх орлогод хамаарахгүй тул Татварын хэлтсээс 2017 оны тайланд залруулга хийсэн, 2 аж ахуйн нэгж, байгууллага хөнгөлөлт эдлэхээр 77.5 мянган төгрөгийн орлогыг үнэн зөв тайлагнаж, хөнгөлөлт эдэлсэн байна. /Хүснэгт 2/

2.2 ААНОАТ-ын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэхээр хүсэлт ирүүлсэн байгууллагын чөлөөлөгдөх орлогын үндэслэлийг Татварын ерөнхий газрын даргын 2009 оны 11 дүгээр сарын 25-ны “Заавар батлах тухай” 531 дугаар тушаалын 1-р хавсралтын 5.3.4¹, 5.3.5²-д заасны дагуу Татварын хэлтсээс нягтлан шалгаж, чөлөөлөлт эдлүүлэх талаар тушаал гаргаж баталгаажуулжээ. Энэ нь тайлан алдаа зөрчилгүй гаргахад нөлөөлсөн байна.

2.3 НӨАТ-ын чөлөөлөлт эдлэх ААНБ нь чөлөөлөгдөх хүсэлтээ Татварын хэлтэст ирүүлэх, Татварын хэлтсээс нягтлан шалгаж, тушаал шийдвэр гаргах талаар хууль,

¹ Татварын улсын байцаагч нь татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэх аж ахуйн нэгжээс ирүүлсэн татварын тайланг хүлээн авахдаа “Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн тооцоо” ТТ-026 маягтын үнэн зөв эсэхийг холбогдох нотлох баримтуудыг үндэслэн тулган шалгаж холбогдох тасгийн дарга /ахлах байцаагч/-аар хянуулан, хөнгөлөлт, чөлөөлөлтийн тооцоо, татварын тайлан тусгагдсан холбогдох мэдээллүүдийг програмд шивж, ААНОАТ-ын тайлангийн хамт татвар төлөгчийн хувийг хэрэгт хавсаргана.

² Жилийн эцсийн татварын тайлан тушаах хугацаа дууссаны дараа татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн мэдээг хөнгөлөлт эдэлсэн хуулийн заалт, орлогын чөлөөлөлт, хөнгөлсөн татварын дүнг аж ахуйн нэгж бүрээр гаргаж, шаардлагатай бол холбогдох эх үүсвэрээс нотлох баримтуудын талаар тодруулга авч, тухайн оны 6 дугаар сарын 30-ны дотор тухайн газар, хэлтсийн даргын тушаалаар баталгаажуулж, татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг эдлүүлнэ.

журмаар зохицуулаагүйгээс тус ажил хийгддэггүй, үүний улмаас НӨАТ-аас чөлөөлөгдөх орлогод хамаарахгүй орлого чөлөөлөгдөж байна.

Энэ нь төсвийн орлого дутуу бүрдэх, хөнгөлөлт чөлөөлөлтийн бодлого зорилтот үр дүнд хүрэхгүй байх үр дагавартай.

2.4. НӨАТ-аас чөлөөлөгдөх орлогод хамаарахгүй орлогод чөлөөлөлт эдэлсэн ААНБ-уудын чөлөөлөлт эдэлсэн татварыг нөхөн төлүүлэх, хууль, журамд заасан холбогдох арга хэмжээ авч ажиллах талаар Дундговь аймгийн Татварын хэлтэст хугацаатай албан шаардлага хүргүүлэв.

2.5 Мөн 2016 онд 3 аж ахуйн нэгж, байгууллага 16,198.6 мянган төгрөгийн орлогыг НӨАТ-аас чөлөөлөгдөх хуулийн үндэслэлийг буруу сонгож тайлагнасан байна. /Хавсралт 2/

Энэ зөрчил нь цаашид буруу мэдээ, тайлан нэгтгэгдэж, алдаатай бодлого, шийдвэр гарахад нөлөөлөх үр дагавартай байна.

Тус зөрчлийг дахин давтан гаргуулахгүй байх, аж ахуйн нэгж, байгууллагад зөвлөмж өгч ажиллах талаар Дундговь аймгийн Татварын хэлтэст хугацаатай албан шаардлага хүргүүлсэн.

Хөдөлмөрийн чадвараа алдсан хөдөлмөр эрхэлдэг иргэд ХХОАТ-ын чөлөөлөлтөд бүрэн хамрагдахгүй байна.

2.6 Дундговь аймгийн Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтсийн дэргэдэх Эмнэлэг хөдөлмөр магадлалын комиссоос тогтоосон хөдөлмөрийн чадвараа 50-иас дээш хувиар алдсан хөдөлмөр эрхэлдэг 39 иргэн бүртгэгдсэн боловч аймгийн Татварын хэлтэст 2016 онд 23 иргэн ХХОАТ-ын чөлөөлөлт эдлэхээр хүсэлт ирүүлж, чөлөөлөлтөд хамрагджээ.

Бүртгэлтэй иргэд бүрэн хамрагдахгүй байгаад Эмнэлэг хөдөлмөр магадлалын комисс, Татварын хэлтэс хоорондын үйл ажиллагааны уялдаа холбоогүй байдал нөлөөлж, мөн тухайн иргэд болон тэдгээрийн ажиллаж буй байгууллагын удирдлага, нягтлан бодогчийн татварын чөлөөлөлтийн талаар мэдлэг, мэдээлэл хомс байгаатай холбоотой байна.

2.7 Иймд аймгийн Татварын хэлтэст Эмнэлэг хөдөлмөрийн магадлалын комисстой хамтарч ажиллах, байгууллагын удирдлага, нягтлан бодогч, хөгжлийн бэрхшээлтэй хөдөлмөр эрхэлдэг иргэдэд сургалт сурталчилгаа зохион байгуулах зөвлөмж хүргүүлээ.

Татварын хэлтсийн хяналт шалгалтаар татварын хөнгөлөлт чөлөөлөлттэй холбоотой зөрчил илрээгүй байна.

2.8 Дундговь аймгийн Татварын хэлтсээс 2015-2016 онуудад хийгдсэн хяналт шалгалтаар татварын хөнгөлөлт, чөлөөлөлттэй холбоотой зөрчил гараагүй байна.

2.9 ААНБ-ууд 2015-2016 онд татвараас чөлөөлөгдөх орлогод хамааралгүй зарим орлогод хөнгөлөлт, чөлөөлөлт эдэлжээ. Дээрх хугацаанд эдгээр ААНБ-уудын үйл

ажиллагаанд татварын байгууллагаас хяналт шалгалт хийгдээгүй бөгөөд харин Сайнмандал ХХК-нд хяналт шалгалт хийсэн байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

Орон нутгийн нийгэм, эдийн засагт татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн үзүүлэх нөлөө бага байна.

- *Хөнгөлөлт, чөлөөлөлт эдэлсэн нийт орлогын 48 хувийг Засгийн газрын бондын хүүгийн орлого эзэлж байна.*
- *Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн хэмжээ нийт орон нутгийн төсвийн орлогын дүнд бага хувийг эзэлж байна.*

НӨАТ-аас чөлөөлөгдөхөөр тайлагнасан нийт орлогын 31 хувийг буруу тайлагнасан байна.

- *НӨАТ-аас чөлөөлөгдөх орлогод хамаарахгүй орлогод чөлөөлөлт эдэлсэн байна.*
- *Хөдөлмөрийн чадвараа 50-иас дээш хувь алдсан хөдөлмөр эрхэлдэг иргэд ХХОАТ-ын чөлөөлөлтөд бүрэн хамрагдахгүй байна.*
- *Татварын хэлтсийн хяналт шалгалтаар татварын хөнгөлөлт, чөлөөлөлттэй холбоотой зөрчил илрээгүй байна.*

ДЭЭД ШАТНЫ БАЙГУУЛЛАГАД ХҮРГЭХ САНАЛ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах саналыг Татварын ерөнхий газарт хүргүүлэхээр ҮАГ-т уламжилж байна. Үүнд:

- *Аж ахуйн нэгж, байгууллагууд НӨАТ-аас чөлөөлөгдөх хүсэлтийг Татварын хэлтэст хүргүүлж, Татварын хэлтэс тус хүсэлтийг нягтлан шалгаж, чөлөөлөх тушаал шийдвэр гаргадаг байх талаар журмын зохицуулалт хийх.*

ЗӨВЛӨМЖ

Аудитаар илрүүлсэн зүйл, аудитын дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан байгууллага, албан тушаалтанд зөвлөж байна.

Дундговь аймгийн Татварын хэлтэст:

- Эмнэлэг хөдөлмөрийн магадлалын комисстой хамтарч ажиллах, байгууллагын удирдлага, нягтлан бодогч, хөгжлийн бэрхшээлтэй хөдөлмөр эрхэлдэг иргэдэд сургалт сурталчилгаа зохион байгуулах.

ШАЛГАГДАГЧ БАЙГУУЛЛАГААС ИРҮҮЛСЭН САНАЛ ТАЙЛБАР

Төрийн аудитын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.1-т заасны дагуу аудитын тайлангийн төслийг аймгийн Татварын хэлтсийн даргад танилцуулж, санал тайлбарыг авлаа.



ДУНДГОВЬ АЙМАГ
ТАТВАРЫН ХЭЛТЭС

48090 Мандалговь, Сайнцагаан сум

Утас, Факс: 7059-3033

E-mail: dundgobi@mta.mn

2017-09-26 № 08/420

танай 2017-09-18 -ны № 172 -Т

Г ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн бодлого, түүний хэрэгжилт, үр дүнгийн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа. Танилцуулгад дурьдсан хугацаатай албан шаардлагуудыг тухай бүр нь залруулна.

У. Борхсайхан
Тайлангийн төслийг
73 он турлаар
танилцуулж

ТАЙЛАНГ БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2017 оны 09 сарын 29 өдөр

Дугаар А/21

Мандалговь

Г Гүйцэтгэлийн аудитын тайланг
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 121 дүгээр тушаал, Гүйцэтгэлийн аудитын журмын 12 дугаар зүйлийн 12.40, Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журмын 4.2-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн бодлого, түүний хэрэгжилт, үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан /УАГ-ГАГ/2017/10-ГА/г баталсугай.
2. Аудитаар илэрсэн зөрчлийн жагсаалт (албан шаардлага, зөвлөмж)-ыг хавсралтаар баталсугай.
3. "Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн бодлого, түүний хэрэгжилт, үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг Үндэсний аудитын газар болон аймгийн Татварын хэлтэст тус тус хүргүүлсүгэй.
4. Гүйцэтгэлийн аудитаар илэрсэн зөрчлүүдийг арилгаж, албан шаардлага зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангуулан, үр дүнгийн талаар 2017 оны 11 дүгээр сарын 24-ний дотор аудитын газарт хариу ирүүлэхийг аймгийн Татварын хэлтсийн дарга /М.Туяацэцэг/, татварын улсын ахлах байцаагч /П.Цэцэгжаргал/ нарт тус тус зөвлөсүгэй.
5. Аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2018 оны 1 дүгээр улиралд гарган танилцуулахыг аудитын менежер /Х.Наранцацрал/, гүйцэтгэлийн аудитын албаны ахлах аудитор /Ч.Бэрхсайхан/ нарт үүрэг болгосугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Т.ОЮУНЧИМЭГ



D:\office\Tushaal\A4\tailan batalgaajuulah tushaal.docx

0000000020



Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын
төргүүлэх аудиторын 2017 оны 2-дугаар сарын
ны өдрийн 14 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

Аудитаар илрүүлсэн зөрчлийн жагсаалт

Аудитын код: ҮАГ-ГАГ/2017/10-ГА

Аудитын нэр: "Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн бодлого, түүний хэрэгжилт, үр дүн"

№	Зөрчлийн товч утга	Зөрчигдсэн хуулийн заалт	Зөрчлийн дүн сая.төг	Үүнээс				Сая төгрөг	
				Аудитын явцад баригдүүлсан	Акт тавигдсан	Албан шаардлага өрсөн	Зөвлөмжөөр өрсөн	Үр өгөөжийн	Мөнгөн дүн
1	Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөгдөх орлогод хамаарахгүй орлогод чөлөөлөлт эдэлсэн.	Татварын ерөнхий хуулийн 28.1.4, 18.1.1, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 13.10, 8.2, 13.7, 13.12	29.68			29.68		1	29.68
2	Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөгдөх орлогын хуулийн үндэслэлийг буруу сонгосон.	Татварын ерөнхий хуулийн 17.1.2, 18.1.1, 8.2	16.20			16.20		1	16.20
3	Хөдөлмөрийн чадвараа 50-иас дээш хувиар алдсан хөдөлмөр эрхэлдэг иргэд ХХОАТ-ын чөлөөлөлтөд бүрэн хамрагдаж чадахгүй байна.		0					1	
Дүн			45.88	-	-	45.88	-	3	45.88

АУДИТЫН ГАЗАР

ТАЙЛАНГИЙН ХАВСРАЛТ

Хавсралт №1

Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөгдөх орлогод хамаарахгүй орлогод чөлөөлөлт эдэлсэн орлогын судалгаа

/Мянган төгрөг/

№	Татвар төлөгчийн нэр	Чөлөөлөгдсөн үндэслэл	Чөлөөлөгдөх орлогод хамаарахгүй шалтгаан	Чөлөөлөгдсөн орлогын дүн		Нийт
				2015	2016	
1	Дэлгэр баяндалай	Засгийн газар, түүний харьяа болон төсөвт байгууллагуудаас үзүүлж байгаа төрийн үйлчилгээ	Тус байгууллага нь Засгийн газар, түүний харьяа болон төсөвт байгууллагад хамаарахгүй	-	2,521.9	
2	Ембүүт булаг	Засгийн газар, түүний харьяа болон төсөвт байгууллагуудаас үзүүлж байгаа төрийн үйлчилгээ	Тус байгууллага нь Засгийн газар, түүний харьяа болон төсөвт байгууллагад хамаарахгүй	857.70	-	
3	Эм хангамж	Эрүүл мэндийн үйлчилгээ	Эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлээгүй	-	49.2	
4	Эм хангамж	Соёлын өвийг сэргээн засварлах үйлчилгээ;	Соёлын өвийг сэргээн засварлах үйлчилгээ үзүүлээгүй	-	2.4	
5	Тэвш есөн эрдэнэ	Борлуулсан сонин	Сонин борлуулах үйл ажиллагаа эрхлээгүй	-	186.0	
6	Тэвш есөн эрдэнэ	Жижиг дунд үйлдвэрийн үйлдвэрлэлийн зориулалт бүхий тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл	Тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл борлуулах үйл ажиллагаа явуулдаггүй	-	1,684.3	
7	Борхацавч	Засгийн газар, түүний харьяа болон төсөвт байгууллагуудаас үзүүлж байгаа төрийн үйлчилгээ	Тус байгууллага нь Засгийн газар, түүний харьяа болон төсөвт	6,151.4	-	

			байгууллагад хамаарахгүй			
8	Өлзийтийн өсөх	Эмчилгээний зориулалтаар хэрэглэх цус, цусан бүтээгдэхүүн, эд эрхтэн	Тус чөлөөлөгдсөн үндэслэлээр үйл ажиллагаа явуулаагүй	8,654.6	-	
9	Сайнмандал	Монгол Улсын нутаг дэвсгэрт байнга оршин суудаг гадаадын дипломат төлөөлөгчийн болон консулын газар, Нэгдсэн үндэсний байгууллага түүний төрөлжсөн салбарын хэрэгцээнд зориулан импортолсон бараа	Тус чөлөөлөгдсөн үндэслэлээр үйл ажиллагаа явуулаагүй	2,209.1	-	
10	Сайнмандал	боловсролын болон мэргэжлийн сургалт явуулах тусгай зөвшөөрөлтэй иргэн, хуулийн этгээдийн эрхлэн гүйцэтгэж байгаа дүрэмд нь заасан боловсрол, мэргэжил олгох үйлчилгээ	Тус чөлөөлөгдсөн үндэслэлээр үйл ажиллагаа явуулаагүй	2,034.5	-	
11	Сүлд морь	Энэ хуулийн 12.1.7-д зааснаас бусад уул уурхайн бүтээгдэхүүн	Тус чөлөөлөгдсөн үндэслэлд хамаарахгүй	5,326.2	-	
НИЙТ				25,233.4	4,443.7	29,677.1

Хавсралт №2

Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөгдөх орлогын хуулийн үндэслэлийг буруу сонгосон судалгаа

№	Татвар төлөгчийн нэр	Чөлөөлөгдсөн үндэслэл	Чөлөөлөгдөх ёстой үндэслэл	/Мянган төгрөг/	
				Чөлөөлөгдсөн орлогын дүн	
				2015	2016
1	Мандалговь хүнс	Жижиг дунд үйлдвэрийн үйлдвэрлэлийн зориулалт бүхий тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл	Монгол Улсын нутаг дэвсгэрт дотоодын түүхий эдээр боловсруулан дотооддоо борлуулсан хүнсний сүү, сүүн бүтээгдхүүн	-	1,119.8
2	Дундговь-Ус	Гаалийн байгууллагаас баталсан, зорчигчдод татваргүй нэвтрүүлэхийг зөвшөөрсөн хэмжээ бүхий зорчигчдын биедээ авч яваа хувийн хэрэглээний бараа	Гадаад улсын Засгийн газар, төрийн бус байгууллага, олон улсын болон буяны байгууллагаас буцалтгүй болон хүмүүнлэгийн тусламжаар авсан бараа	-	198.8
3	Шувуутай-Оргил	Монгол Улсаас гадаад улсад суугаа дипломат төлөөлөгчийн болон консулын газрын албан ажлын болон тэдгээрт ажиллагчдын хувийн хэрэгцэнд зориулан худалдаж авсан бараа, ажил, үйлчилгээг тухайн улсад албан татвараас чөлөөлдөг бол тэр улсаас Монгол Улсад суугаа дипломат төлөөлөгчийн болон консулын газрын албан ажлын болон тэдгээрт ажиллагчдын хувийн хэрэгцээнд зориулж Монгол Улсын нутаг дэвсгэрт худалдан авсан бараа, гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээ	Гадаад улсын Засгийн газар, олон улсын байгууллагаас хүмүүнлэгийн болон буцалтгүй тусламжаар авсан бараа, буцалтгүй болон хүмүүнлэгийн тусламж, хөнгөлөлттэй зээлийн хүрээнд гадаад улсын Засгийн газар, олон улсын байгууллагаас өгсөн санхүүжилт /мөнгөн хөрөнгө/-ээр дотоодын зах зээлээс худалдан авч байгаа бараа, ажил, үйлчилгээ	-	14,880.0
НИЙТ				-	16,198.6